

## “ИХ МОНГОЛ УЛСЫН ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ ХЯТАД ХОЁР СУРВАЛЖ БИЧИГ” НОМЫН ТУХАЙ

*Н.Төмөр\**

“Их Монгол Улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг” нэртэй шинэ ном 2005 онд Улаанбаатар хотноо хэвлэгджээ. Энэхүү зохиолыг МУИС-ийн ОУХС-ийн тэнхимийн эрхлэгч, тэргүүлэх профессор, түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D) Хэрээд Ж.Баясах бичиж, Монгол Улсын Шинжлэх ухааны гавъят зүтгэлтэн, доктор (Sc.D), профессор Хэрээд Л.Жамсран хянан тохиолдуулсан. Түүхч эрдэмтэн Баясахын толилуулж буй бүтээл нь XIII зууны эхэн үеийн Монголын түүхэнд холбогдох хятад хоёр гол сурвалж бичгийн судалгаа ажээ. Зохиол нь оршил, нэгдүгээр бүлэг. Сурвалж бичгүүдийн тодорхойлолт, хоёрдугаар бүлэг. “Монгол” гэдэг нэр хийгээд XIII зууны эхэн үеийн Их Монгол улсын эдийн засгийн талаархи хятад сурвалжуудын тэмдэглэлийг нягталсан нь, гутгаар бүлэг. Эдийн соёлын талаархи тэмдэглэлийг харьцуулж харшуулсан судалгаа, дөптөөр бүлэг. Оюуны соёлын талаар бичсэн зүйлийг харьцуулж тогтоосон судалгаа, хятад сурвалж бичгүүдийн орчуулга, тайлбар, хятад эх бичиг, дүгнэлт, ном зүй, хэлхээс, 7 хавсралт зураг болон англи хэлний товчлол нийт 410 хуудастайгаар хэвлэгджээ.

“Их Монгол Улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг” гэдэг нь “Хар татаарын хэргийн товч” /“Хэда шилюз”/, “Монгол татаарын бүрэн тэмдэглэл” /“Мэнда бэйлү”/ хоёр сурвалж бичгийг хэлж буй юм. “Хар татаарын хэргийн товч” хэмээх номыг Хятадын Өмнөд Сүн улсаас Их Монгол улсад ирж байсан элч Пэн Да-я, Сюй Тин нарын бичсэн Монголын тухай тэмдэглэл юм. Энэхүү тэмдэглэлийг Пэн Да-я /1233 онд Монголд элчээр ирж байсан/ анхлан бичсэн бөгөөд уг тэмдэглэлд Сюй Тин /1235-1236 онд Монголд ирж байсан/ нэмэлт залруулга хийжээ. “Хар татаарын хэргийн товч” тэмдэглэлд XIII зууны эхний хагасын монголчуудын эдийн болон оюуны соёлтой холбогдох асар их баримт байдаг учир тухайн үеийн монголчуудын нийгэм, улс төр, эдийн засаг, зан заншлыг судлахад чухал сурвалж хэрэглэгдэхүүн болдог. “Монгол татаарын бүрэн тэмдэглэл” -ийг XIII зууны эхээр Их Монгол улсад ирж байсан Хятадын Сүн улсын элч Чжао Хун бичжээ. Түүний бичсэн тэмдэглэлд монголчуудын амьдрал ахуй, улс төр, соёл, зан заншлын талаар хэдийгээр товч боловч тал бүрээс нь өгүүлсэн учир тэр үеийн Монголыг судлахад мөн чухал сурвалж хэрэглэгдэхүүний нэг болж чадсан.

\* Н.Төмөр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Монголын XIII зууны түүхийг судлахад “Хар татаарын хэргийн товч”, “Монгол татаарын бүрэн тэмдэглэл” хятад хоёр сурвалж бичиг нь “Монголын нууц товчоо”, Жиованни Дель Пано Карпини “Монголчуудын түүх”, Гильом Де Рубрук “Дорно этгээдэд зорчсон минь”, Марко Поло “Орчлонгийн элдэв сонин”, Жувейний зохиосон “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” зэрэг сурвалж бичгүүдийн нэгэн адил чухал ач холбогдолтой.

Түүхч эрдэмтэн Ж.Баясахын “Их Монгол Улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг” номд өгүүлэн буй хятад сурвалж бичгүүд нь өрнөдийн жуулчдын тэмдэглэл, Персийн түүхчийн бүтээл болон “Монголын нууц товчоо” хамтаар Монголын XIII зууны нийгмийн бүрэн дүр зургийг гаргаж өгнө. Дээрхи хятад хоёр сурвалж бичгийг гадаадын олон эрдэмтэд Монголын түүхийн чухал сурвалж болно хэмээн үнэлсэн байдаг.

“Их Монгол Улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг” номд урьд өмнө монгол судлалд төдийлөн судлагдаагүй монголчуудын хоол хүнс, хувцас хунар, унаа хөсөг, ахуй амьдралын оюуны соёлын зарим төрөл зүйл, тухайлбал уламжлалт зан үйл, ёс заншил хийгээд цээрлэх ёсны талаархи хятад сурвалж бичгийн мэдээ баримтыг зохиогч задлан шинжилжээ. Ийм судалгааны ажил хийснээрээ эртний монголчуудын соёл хийгээд угсаатны зүйн талаархи үнэн зөв мэдээллийг олж тогтооход чухал ач холбогдолтой. Энэхүү зохиолд хятад хоёр эх сурвалжид тэмдэглэгдсэн монголчуудын амьдрал ахуйн талаар нарийвчлан бичсэн зүйлсийг XIII зууны гадаад дотоодын сурвалж бичгүүдэд буй тэмдэглэлүүдтэй харьцуулсан нь тухайн үеийн Их Монгол улсын дүр төрхийг гаргаж өгсөн төдийгүй сурвалж бичгүүдийн нийтээр хүлээн зөвшөөрсөн хятад зөв эхийг сонгон авч хятадын нэрт түүхч эрдэмтэн Ван Говэйн нарийвчлан хийсэн сурвалж судлалын тайлбарын хамт монгол хэлнээ орчуулан толилуулсан нь уг номын үнэ цэнийг улам өсгөжээ.